



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны

өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль /Цаашид НССДС гэж товчлох/- д суралцагч оюутны суралцах эрх, үүргийг баталгаажуулах, оюутны дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоох, тус сургуулийн хамт олны доторх харилцааг зохицуулах, хариуцлагын тогтолцоог бий болгоход оршино.
- 1.2. НССДС-д суралцагч дотоод, гадаадын оюутны үүргийг баталгаажуулах, сургуулийн хамт олон доторх харилцааг зохицуулах, хариуцлагын тогтолцоог бий болгоход энэхүү дүрэм үйлчилнэ.
- 1.3. НССДС нь аливаа хүчирхийлэл, сүрдүүлэг, ялгаварлан гадуурхалтаас ангид, хууль журмыг ёсчлон биелүүлдэг, ардчилал, хүний эрхийг хүндэтгэн дээдэлдэг, оюутны суралцах таатай орчныг бүрдүүлсэн байна.

ХОЁР. СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

2.1. Үүрэг болгосон хэм хэмжээ

- 2.1.1. Оюутан нь Монгол Улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм, журмын заалт болон сургалтын гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлдэг, идэвх чармайлт гарган суралцана.
- 2.1.2. Оюутан нь сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож, хөндлөнгөөс саад учруулдаггүй, бусдын эрх ашгийг хүндэтгэдэг байна.
- 2.1.3. Оюутан нь гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн дагуу шийтгэл хүлээх бөгөөд хэрэв энэ үйлдэл нь сургуулийн болон хамт олны эсрэг чиглэгдсэн байвал энэ дүрмийн дагуу давхар хариуцлага хүлээнэ.

2.2. Дараах сахилгын зөрчил гаргасан оюутанд зохих хууль, дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

- 2.2.1. Сургалтын гэрээ болон сургуулийн дүрэм, журмын заалтыг зөрчсөн, тэдгээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;
- 2.2.2. Бусдын оюуны өмчийг зөвшөөрөлгүй ашигласан, шалгалтын материалтай урьдчилан танилцсан, хуулсан, сурлагын дүнгийн үнэлгээнд зүй бусаар нөлөөлсөн, хууль бус аргаар



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны

өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

дүн, шагнал, урамшуулал, тэтгэлэг, гэрчилгээ, диплом авсан, хуурамчаар үйлдсэн, үр дүн, тайланг буруу мэдээлсэн;

- 2.2.3. Өдөр тутмын сургалт, үйлчилгээ, дадлагын үйл ажиллагаанд саад учруулсан;
- 2.2.4. Сургуулийн захиргаа, Сургалтын алба, багш нарт хуурамч болон буруу баримт мэдээлэл өгсөн, өөрийн дураар дүн, тайлан, бичиг баримтад засвар хийсэн;
- 2.2.5. Сургуулиас олгосон биеийн байцаалтыг буруугаар ашигласан;
- 2.2.6. Сургуулийн удирдлага, багш нараас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан;
- 2.2.7. Сургуулийн бичиг баримт, мэдээ материалыг гэмтээсэн, устгасан, хуурамчаар үйлдсэн, зөвшөөрөлгүйгээр хувилсан, хэвлэсэн, бусдад дамжуулан өгсөн;
- 2.2.8. Сургуулийн нутаг дэвсгэр, хичээл, сургалтын байр, дотуур байранд бусдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлсөн зохисгүй үйлдэл гаргасан;
- 2.2.9. Сургуулийн дотоод журмыг ноцтойгоор зөрчсөн, бусдыг доромжилсон, заналхийлсэн, турхирсан, эрх чөлөө болон хувийн нууцад нь халдсан, амгалан тайван байдлыг алдагдуулсан, сургуулийн удирдлага, багш ажилчдын хэвийн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээ, захиргаа, олон нийтийн ажлыг үймүүлсэн, тасалдуулсан;
- 2.2.10. Сургуулийн нутаг дэвсгэрт хар тамхи, архи дан согтууруулах ундаа биедээ авч явсан буюу хэрэглэсэн;
- 2.2.11. Сургуулийн өмчид хамаарах хөрөнгө, ном сурах бичиг, эд зүйлс, тоног төхөөрөмжийг зориулалтын бус байдлаар ашигласан, хулгайлсан, гэмтээсэн;
- 2.2.12. Сургуулийн аюулгүйн болон бусад онцгой байдлын тоног төхөөрөмжийг буруугаар ашигласан, тэдгээрт гэмтэл хохирол учруулсан, хариуцсан ажилтны үйл ажиллагаанд саад учруулсан;
- 2.2.13. Сургуулийн байр, эзэмшилд нэвтрэн орох түлхүүрийг зөвшөөрөлгүйгээр ашигласан, бусдад дамжуулсан;
- 2.2.14. Энэхүү дүрмийн заалтуудыг удаа дараалан зөрчсөн.

2.3. Хориглосон хэм хэмжээ:

- 2.3.1. Хичээл таслах, хичээлээс хоцрох, хичээлийн дундуур хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гарч явах;
- 2.3.2. Хичээлийн цагаар бусдын сурах үйл ажиллагаанд саад учруулах, бусдын тавьсан шаардлагыг үл ойшоож, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны

өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

- 2.3.3. Шалгалтын ажлыг гүйцэтгэх явцад бусдад мэдээлэл өгөх, бусдаас мэдээлэл авах, шалгалтанд зөвшөөрөгдөөгүй материал авч орох, ашиглах, гар утас, цахим хэрэгсэл хэрэглэх;
- 2.3.4. Бусдын өмнөөс шалгалт өгөх, бусдыг өөрийнхөө өмнөөс шалгалтанд оруулах;
- 2.3.5. Бие даан гүйцэтгэхээр заасан лабораторийн ажил, дадлага, судалгааны ажил, хичээлийн бие даалтын ажлыг хуурамчаар үйлдэх буюу бусдын бүтээлийг хуулбарлах, хулгайлах, хууран мэхлэх. Доорх тохиолдолд хууран мэхэлсэн гэж үзнэ.
 - 2.3.5.1. Бусдын хийсэн ажил, дэвшүүлсэн санааг өөрийн болгосон;
 - 2.3.5.2. Бусдын ажлыг шууд хуулбарласан;
 - 2.3.5.3. Бусдын санааг зөвшөөрөлгүй, зүй бусаар ашигласан;
 - 2.3.5.4. Нэг хичээлийн даалгаврын гүйцэтгэлд шалгуулж үнэлгээ авсан ажлыг өөр хичээлийн даалгаварт шалгуулж, давхар үнэлүүлэх;
- 2.3.6. Багшийн өгсөн дүн, оноог засч үнэлгээг өөрчлөх;
- 2.3.7. Дүнгийн хуудас, сурлагын дэвтэр, оюутны үнэмлэх, биеийн байцаалт, хөнгөлөлтийн хуудас зэрэг албан бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, өөрчлөн хувиргах, засвар оруулах, зүй бусаар бусдад дамжуулах, ашиглуулах;
- 2.3.8. Суралцах явцад бусадтай шударга бусаар өрсөлдөх
- 2.3.9. Хичээлийн цагаар хичээлд хоблогдолгүй зүйл хийх, утсаар ярих, мессэж бичих, тоглох, цахим хэрэгслийг хичээлийн бус зориулалтаар ашиглах.

ГУРАВ. СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БУСАД ХҮРЭЭНД МӨРДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

3.1 Үүрэг болгосон хэм хэмжээ

- 3.1.1 Багш, ажилтан, ажилчид, бусад суралцагчидтай харилцааны өндөр соёлтой, хүндэтгэлтэй харилцана.
- 3.1.2 НССДС-ийн анги танхим, лаборатор, дотуур байр, номын сан, уншлагын танхим, биеийн тамирын заал, хоолны газар, коридор зэрэг нийтийн эзэмшлийн байр, талбай, тэдгээрт ашиглагдаж буй эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ариг гамтай, зориулалтын дагуу ашиглаж, зөв боловсон үйлчлүүлнэ.

3.2 Хориглосон хэм хэмжээ

- 3.2.1 Дэглэх Анги, курс, хот хөдөө, нас, физиологийн ялгаа үүсгэн бусдыг айлган сүрдүүлэх, эрхшээлдээ оруулах, зодож гэмтээх, элдэв дарамт учруулах, нэр хүндийг нь гутаан доромжлох;



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны

өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

- 3.2.2 Хүнлэг буй үйлдэл гаргах Хуурамч дуудлага өгөх, бусдыг хилсээр буруутгах, мэдсээр атлаа мэдээллийг гуйвуулах, нуун дарагдуулах, худал мэдээлэх, цохилдуулах зэрэг ноцтой үйлдэл гаргах, багш, ажилтан, ажилчдыг гүтгэх, худал мэдүүлэг өгөх;
- 3.2.3 Шаардлага үл биелүүлэх. Сургуулийн эрх бүхий албан тушаалтан, багш, ажилтан, ажилчид суралцагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, биеийн байцаалтаа гаргаж өгөхгүй байх, сахилгын арга хэмжээг үл биелүүлэх;
- 3.2.4 Дур мэдэн хэсэх. Сургуулийн анги, танхим, албан тасалгаа, дотуур байранд зөвшөөрөлгүй нэвтрэх, дотор нь байрлах;
- 3.2.5 Суралцах орчны амгалан тайван байдлыг алдагдуулах Сургуулийн анги танхим, лаборатори, дотуур байр, номын сан, бие даан ажиллах төв, биеийн тамирын заал, хоолны газар, нийтийн эзэмшлийн байр, талбайд хэт чанга дуу авиа гаргах, орилох, исгэрэх, чанга инээлдэх, хөгжим дуугаргах;
- 3.2.6 Суралцах орчинг бохирдуулах. Сургуулийн анги танхим, лаборатори, дотуур байр, номын сан, уншлагын танхим, биеийн тамирын заал, хоолны газар зэрэг нийтийн эзэмшлийн байр, талбайд элдэв хог хаягдал, тамхины иш зэргийг хаях, цонхоор элдэв юм шидэх;
- 3.2.7 Бусдын хөдөлмөрийг үл хүндэтгэх. Цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул, хамгаалалтын ажилчдыг үл ойшоох, хөдөлмөрийг нь үл хүндлэх;
- 3.2.8 Аюултай зэвсэг хэрэглэх Хуулиар зөвшөөрсөн эсэхээс үл хамааран сургуулийн зохих албан тушаалтан зөвшөөрсөн, сургуулийн дүрэм, журамд зааснаас бусад тохиолдолд хүйтэн зэвсэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, шатамхай бодис зэрэг аюултай зэвсэг, хэрэглэл ашиглах, хадгалах, эзэмшилдээ байлгах;
- 3.2.9 Мансууруулах бодис Хуулиар хориглосон арга, хэлбэрээр мансууруулах бодис хэрэглэх, үйлдвэрлэх, түгээх, борлуулах, эзэмшилдээ байлгах;
- 3.2.10 Мөрийтэй тоглох НССДС-ийн орчинд хэзэр, даалуу, компьютерийн тоглоом тоглох, мөрийтэй тоглох.

ДӨРӨВ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 4.1. Энэхүү ёс зүйн дүрмийг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.
- 4.1.1. Сахилгын зөрчил гаргасан оюутанд дараах арга хэмжээг авна. Үүнд:
 - 4.1.1.1. Амаар буюу бичгээр анхааруулах;
 - 4.1.1.2. Эрхийг хязгаарлах, дотуур байрнаас гаргах, диплом олгохыг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, сургуулиас олгосон биеийн байцаалт болон сургуулийн бусад өмч хөрөнгийг хураах, хохирлыг төлүүлэх;



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны

өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

- 4.1.1.3. Тодорхой нөхцөлтэйгээр үргэлжлүүлэн суралцуулах;
- 4.1.1.4. Тодорхой хугацаагаар суралцах эрхийг нь хасах, эсвэл зарим хичээлд суух эрхийг нь хасах;
- 4.1.1.5. Сургууль, хамт олны нэр хүндийг ул үндэсгүйгээр гүтгэсэн, доромжилсон, энэ үйлдлээ мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн, өмч, эд хөрөнгө, аюулгүй байдал, сургалтын хэвийн үйл ажиллагаанд учруулсан хохирлын хэмжээнээс шалтгаалан сургуулийн захиргаа тухайн оюутныг сургуулийн ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүйгээр Захирлын тушаалаар сургуулиас хөөж болно. Энэ арга хэмжээг дараах тохиолдолд авна:
 - 4.1.1.5.1. Зөрчил удаа дараа давтагдсан;
 - 4.1.1.5.2. Сургуульд их хэмжээний хохирол учруулсан, нэр төрд нь халдсан гэж үзвэл.

ТАВ. ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

- 5.1. Сургууль нь оюутны ёс зүйн зөвлөл (цаашид "зөвлөл" гэнэ)-тэй байж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүнд захиргаа, багш, оюутны холбоо, зөвлөл, эцэг эхийн төлөөллөөс гадна хөндлөнгийн төлөөлөл орж болно. Зөвлөлийн хурлаар ёс зүйн дүрмийг зөрчсөн оюутны асуудлыг хурлаараа хэлэлцэн зөвлөмж гаргаж, сургуулийн захиргаанд өгнө. Хурал ил тод, нээлттэй, шударга зарчмаар явуулна.
- 5.2. Зөвлөлийн бүрэлдэхүүн шийдвэр гаргах, хариуцлага тооцох харилцааг сургуулийн хамт олны хурлаар хэлэлцэн батална.
- 5.3. Уг дүрмийн дагуу арга хэмжээ тооцогдсон оюутан нь хариуцлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй гэж үзвэл МОХ-ны дэргэдэх ёс зүйн хороонд хандах эрхтэй. Оюутны эрхийг хамгаалах үүднээс ёс зүйн хороо нь асуудлыг дахин хэлэлцэх, тайлбарыг нь сонсох, зохих шийдвэрийг гаргана.

-----Х-----